



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 19/102

Мандалговь

“Таван богд” ХХК-тай
гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 04 сарын 13-ны өдрийн 14 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт, Аймгийн Засаг даргын 2022 оны 02 сарын 12-ны өдрийн А/42 тоот захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих их засварын хөдлөх хөрөнгийн их засвар үйлчилгээний батлагдсан зардлаас “0022ДУА дугаартай парадо 150 маркын ажлын албаны автомашины засвар” ажлыг “Таван богд” ХХК-тай 3,325,700 (гурван сая гурван зуун хорин таван мянга долоон зуу) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Гэрээнд заасан хугацаанд “0022ДУА дугаартай парадо 150 маркын ажлын албаны автомашины засвар” ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Таван богд” ХХК-ний гүйцэтгэх захирал (Ж.Барсболд)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Үйлчилгээний албаны дарга (М.Батсайхан) гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭЧ

Л.ДОРЖБАТ

4822150236